

Монгол Улс

Нэг цэгийн үйлчилгээ: Дэлхийн хүн ам хамгийн тархуу суурьшсан улс болох Монгол Улс иргэддээ чанартай нийгмийн үйлчилгээг хүргэх шийдэл нь нэг цэгийн үйлчилгээ юм.

2007 онд эхлэл нь тавигдаж, 2013 оноос улс орон даяар нэвтэрсэн нэг цэгийн үйлчилгээ(НЦҮ)-ний төвүүдээр аймаг, сумын түвшинд нийгмийн хамгааллын болон хөдөлмөр эрхлэлтийн зөвлөгөө өгөх үйлчилгээ, түүнчлэн нотариатын болон банкны үйлчилгээг үзүүлдэг.


Нийгмийн даатгал, халамж, хөдөлмөр эрхлэлтийн болон бусад асуудал эрхэлсэн төрийн байгууллагуудын төлөөлөгчид нэг дороос үйлчилгээ үзүүлдэг болсноор төрийн үйлчилгээг хүргэх хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, тэдгээрийн талаарх ойлголт мэдээлэл, ил тод байдлыг сайжруулах боломжийг Засгийн газарт олгосон байна.

Эдүгээ иргэд өргөнөөр үйлчлүүлэх болсон НЦҮ нь төрийн үйлчилгээний чанар, зохицуулалтыг сайжруулах боломжийг орон нутгийн удирдлагуудад олгож байна.

Үндэсний нийгмийн хамгааллын суурь түвшин (НХСТ) нь хүн бүрийг зайлшгүй шаардлагатай эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулах, хүүхэд, хөдөлмөрийн насны хүмүүс болон ахмад настнуудын орлогын суурь баталгааг хангах зорилготой.

Бүх нийтийг нийгмийн хамгаалалд хамруулахад чиглэсэн Нийгмийн хамгааллын суурь түвшний тухай 2012 оны 202 дугаар зөвлөмжийг 185 орны төлөөлөгчдийн оролцоотойгоор батлан гаргасан юм.

Энэхүү хураангуйд нийгмийн хамгааллыг амжилттай өргөжүүлж буй орны туршлагыг танилцуулж байна.



Гол сургамж:

- Хүн ам нь хамгийн тархуу суурьшсан улсын хувьд ч нийт хүн амд нийгмийн хамгааллын үйлчилгээг баталгаатай хүргэх боломж бий.
- НЦҮ нь хүмүүс төрөөс хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдийн талаарх мэдээлэл, нийгмийн үйлчилгээ, тэтгэвэр, тэтгэмжийг нэг газраас авах боломжийг олгодог үйлчилгээний цэг бөгөөд нийгмийн хамгааллын хамрах хүрээг өргөжүүлэхэд хувь нэмрээ оруулдаг.
- Түүнчлэн ахмад настан, малаа орхиод НЦҮ-ний төвд очиж үйлчлүүлж чадахгүй малчид зэрэг хүмүүст явуулын НЦҮ-гээр үйлчилгээг гэрт нь хүргэдэг байна.
- Бүх үйлчилгээг нэг цэгээс үзүүлдэгээрээ НЦҮ нь нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиг үүрэгтэй байгууллагуудын үйл ажиллагааны давхардал, үр ашиггүй байдлыг багасгахын зэрэгцээ тэдгээрийн хоорондын уялдаа зохицуулалтыг сайжруулдаг. Энэ нь мөн нийгмийн халамж, даатгалыг хэт тусгаарлах явдлыг багасгаж, нийгмийн хамгааллын цогц тогтолцоо бүрдүүлэхийг дэмждэг.
- НЦҮ-г нийгмийн хамгааллын тогтолцооны болон орон нутгийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хянаж, үнэлэх нэгдсэн тогтолцоог бүрдүүлэхэд ашиглаж болно.

Нийгмийн хамгааллын суурь түвшнийг бүрдүүлэх нь

Нийгмийн хамгаалал амьдралд:

2016 оны 2 дугаар сар

1. Хүн ам нь хамгийн тархуу суурьшсан орны алслагдмал газар нутагт чанартай үйлчилгээ хүргэхэд тулгардаг сорилт

Монгол Улс нь 2.8 сая хүн амтай, нэг квадрат километр газарт 2-оос цөөн хүн ногддог дэлхийн хамгийн тархуу суурьшилтай орон юм. Уул уурхайн салбарын хөгжилтэй холбоотойгоор Монгол Улсын эдийн засаг сүүлийн жилүүдэд хурдацтай өсч байна.

Монгол Улс нь хүний амьдралын мөчлөг бүрт тохирсон нийгмийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг үзүүлдэг нийгмийн хамгааллын тогтолцоотой (нийгмийн даатгал, нийгмийн халамж, хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлого). 2012 оны байдлаар хүн амын 97.8 хувь нь эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байв (эрүүл мэндийн даатгал нь хүн амын тодорхой бүлгүүдийн болон эмзэг хэсгийн төлөх шимтгэлийг төрөөс хариуцдаг албан журмын даатгал юм).

Гэхдээ хүн ам их тархуу суурьшсан улсад нийгмийн үйлчилгээ, тэтгэвэр, тэтгэмжийг хүн амд хүргэхэд бэрхшээлтэй байдаг. Монгол Улсад төрийн захиргааны үйлчилгээ авахын тулд бие биеэсээ харьцангуй зайтай оршдог хэд хэдэн өөр байгууллагад очих шаардлага олонтаа тулгардаг. Тиймээс үйлчилгээнд хамрагдах хүсэлт гаргахад нэлээдгүй цаг хугацаа зарцуулахаас гадна тээврийн зардал ч гардаг. Харин хөдөөгийн сумдаас аймгийн төврүү явах шаардлагатай хүмүүсийн хувьд байр, хоолны зэрэг нэмэлт зардал ч гардаг байна. Түүнчлэн хүмүүс мэдээлэл дутмаг, буруу мэдээлэлтэй, эсвэл мэдээлэл олж авахад хүндрэлтэй байх тохиолдол бий.

Швейцарийн хөгжлийн хамтын ажиллагааны агентлагийн дэмжлэгтэйгээр Хүний аюулгүй байдлын судалгааны төв төрийн бус байгууллагаас хэрэгжүүлсэн төслийн хүрээнд 2007 онд иргэд төрийн зарим төрлийн үйлчилгээ, хувийн хэвслээс үзүүлдэг нотариатын болон банкны үйлчилгээг нэг дороос авах бүтцийг бий болгосон байна. Үйлчлүүлэгч төвтэй, хүртээмжтэй үйлчлэх “нэг цэгийн үйлчилгээний төвүүд” нь төрийн үйлчилгээний хүртээмж, ил тод байдал, үр ашгийг дээшлүүлэх, түүнчлэн авилга, нэмэлт зардлыг бууруулахыг зорьсон байна.

Туршилтын энэхүү төслийн үр дүнд тулгуурлан Засгийн газрын 2013 оны 153 дугаар тогтоолоор “Нэг цонхны үйлчилгээ”-ний төвийн үйл ажиллагааны журмыг батлан гаргаж, НЦҮ-г улс орон даяар нэвтрүүлсэн байна.

2. Орон нутгийн Засаг даргын тамгын газрын байрны нэг өрөөнд хэд хэдэн байгууллага, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хариуцсан ажилтнууд хамтдаа сууж, үйлчилгээ үзүүлдэг

НЦҮ-ний тухай Засгийн газрын 2013 оны 153 дугаар тогтоолд Улаанбаатар хотын дүүрэг, хороо, аймаг, сум зэрэг Монгол Улсын засаг захиргааны нэгжид уг үйлчилгээг бий болгож ажиллуулахаар заасан байна. НЦҮ-г тухайн шатны Засаг даргын тамгын газрын дарга хариуцан зохион байгуулдаг.

НЦҮ-нд дараах байгууллага, хөтөлбөр, үйлчилгээг хамруулна:

- нийгмийн даатгал
- нийгмийн халамж
- хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ
- газрын харилцааны үйлчилгээ
- иргэний бүртгэлийн үйлчилгээ
- банкны болон нотариатын үйлчилгээ.

Түүнчлэн тухайн орон нутгийн онцлог хэрэгцээнд үндэслэн НЦҮ-нд бусад төрлийн (мал эмнэлгийн гэх мэт) үйлчилгээг нэмж хамруулж болно.

НЦҮ-ний төвд ажиллаж буй ажилтан нь төрийн албан хаагч, харьяа байгууллага, газар, хэлтсийн үндсэн ажилтан байдаг. Эдгээр ажилтан нь ажлаа шууд харьяа байгууллагынхаа удирдлагад тайлагнадаг бөгөөд Засаг даргын тамгын газрын даргад тайлагнах механизм байхгүй. НЦҮ-г хэвийн, тогтвортой явуулах асуудлыг Засаг даргын тамгын газрын дарга хариуцдаг.



© ОУХБ/Н.Мөнхбаатар 2014

Үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, өөрсдөө ирж үйлчлүүлэх боломжгүй (ахмад настан, малчид зэрэг) хүмүүсийн гэрт нь үйлчилгээг хүргэх зорилгоор 2011 онд явуулын (машинтай) НЦҮ-г Улаанбаатар хотын Багахангай дүүрэгт түршжээ.

Энэхүү санаачлагыг өргөжүүлж, алслагдмал газар нутгийн хүмүүст төрийн үйлчилгээг хүргэхийн тулд явуулын НЦҮ-г одоо дахин 2 аймагт хэрэгжүүлж эхлээд байна.

3. НЦҮ-ний ачаар төрийн үйлчилгээний хүртээмж сайжирч байна.

Монгол Улсын хүн амын 60 гаруй хувь нь НЦҮ-ний төвөөр тогтмол үйлчлүүлж байна. 2011 онд НЦҮ-ний 31 төвөөр 1.8 сая гаруй хүн үйлчлүүлсний 600 мянга нь Улаанбаатар, 1.2 сая нь хөдөө орон нутагт байжээ. Мөн 2011 онд явуулсан дотоод судалгаагаар үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 85 хувьтай гарсан байна.

Төрийн олон төрлийн үйлчилгээг нэг байрлалд төвлөрүүлэн үзүүлснээр үйлчлүүлэгчид эдгээр үйлчилгээг авахад зарцуулах цаг хугацаа, зардлыг хэмнэх боломжийг олгосон байна. Нийгмийн хамгааллын салбарын хувьд НЦҮ-г нэвтрүүлснээр тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээнд хамрагдах хүсэлт гаргах, авах журмыг тодорхой болгож, хялбаршуулжээ. Тэтгэвэр, тэтгэмж авах үе шатуудыг дэлгэрэнгүй дүрсэлж тайлбарласан зааврыг иргэдэд зориулан боловсруулж, НЦҮ-ний төвүүдэд байрлуулсан байна. Түүнчлэн орон нутгийн засаг захиргааны олонх нь НЦҮ-ний төвөөс авах үйлчилгээнүүд болон тус төвөөр үйлчлүүлэхээр очихдоо бүрдүүлэх бичиг баримтын талаар иргэдэд үнэн зөв мэдээлэл өгөх үүднээс лавлах утас ажиллуулж байна.



Нийгмийн халамжийн тусламж авах хүсэлт гаргаж хамрагдах үйл явцыг иргэдэд тайлбарлаж харуулсан заавар

НЦҮ-ний байранд өөр өөр үйлчилгээ хүргэдэг байгууллагын ажилтнууд нэг дор байрлах болсон нь нийгмийн халамж, нийгмийн даатгал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээний хоорондын уялдааг сайжруулахад түлхэц болжээ. Зарим газарт орон нутгийн өрхүүдийн хэрэгцээ шаардлагад илүүтэй нийцсэн арга хэмжээ, үйлчилгээг багцлан хүргэж, ядуурлыг илүү үр дүнтэй бүүруулах зорилгоор эдгээр байгууллагууд хоорондоо хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан байна.

4. Цаашдын алхам

Сум, хороо бүрт НЦҮ-г бий болгох ажил хараахан дуусаагүй байна. Тиймээс Засгийн газар өмнө хүрсэн амжилт, хүримтлүүлсэн түршлагадаа үндэслэн 2013 оны 153 дугаар тогтоолыг бүрэн хэрэгжүүлэх чиглэлд ажиллах хэрэгцээ байна.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн өөр өөр түвшинд ажиллаж буй НЦҮ-ний төвүүдийн үйл ажиллагааг босоо чиглэлд уялдуулах, түүнчлэн удирдлагын төвлөрсөн босоо тогтолцоо бүхий байгууллагуудын салбар, нэгжүүдийн үйл ажиллагаатай НЦҮ-ний төвүүдийн үйл ажиллагааг хэрхэн зохицуулж уялдуулах асуудлыг тодорхой болгох нь зүйтэй. Одоогийн байдлаар НЦҮ-ний төвүүд болон улсын хэмжээний байгууллагуудын харьяа орон нутгийн нэгжүүд нь үйлчлүүлэгчдийг татах тал дээр өрсөлдөгчид болоод байна. Тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй НЦҮ-ний төвүүдийн хоорондын уялдааг хангаж, НЦҮ-нд хамрагдсан байгууллагуудын салбар, нэгжүүдээс үзүүлж буй үйлчилгээ, үйл ажиллагаанд нэмэлт болох байдлаар зохион байгуулах нь зүйтэй.

Өнөөгийн байдлаар НЦҮ-ний төвд ажиллаж буй ажилтан бүр үйлчлүүлэгчдийнхээ бүртгэлийг тусдаа хөтөлж, бусад байгууллагын ажилтнуудтай хуваалцахгүй байна. Хүн бүрийг бүртгэлийн дугаараар нь оруулдаг үйлчлүүлэгчдийн нэгдсэн мэдээллийн сантай болох нь бүртгэл, мэдээллийн үйл явцыг улам хялбаршуулж, хөтөлбөрүүд хоорондын уялдааг сайжруулж, үндэсний хэмжээний мэдээ тайлан гаргах, орон нутгийн хөгжлийг төлөвлөгөөг боловсронгуй болгох зэрэгт ашиглаж болохуйц хяналт, шинжилгээ үнэлгээний нэгдмэл бүрдэх эхлэлийг тавина.

Монгол Улс чамгүй хүчин чармайлт гаргаж, зохих үр дүнд хүрч байгаа хэдий ч иргэд хөтөлбөр, үйлчилгээнд хамрагдаж, тэтгэвэр, тэтгэмж авах үйл явц бусад орнуудтай харьцуулахад нэлээд түвэгтэй хэвээр байна. Энэ бүхнийг хэрэглэгч, үйлчлүүлэгчийн талаас нь харж илүү хялбаршуулах, төрийн байгууллагууд хоорондын хамтын ажиллагааг дэмжих шаардлагатай байж болох юм.



АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Олон улсын хөдөлмөрийн товчоо (ОУХТ). 2012. Нийгмийн хамгааллын суурь түвшний тухай зөвлөмж(202). Олон улсын хөдөлмөрийн бага хурал, 101 дүгээр чуулган, Женев, 2012 (Женев).

http://www.ilo.org/dyn/normlex/en/f?p=NORMLEXPUB:12100:0::NO::P12100_ILO_CODE:R202.

–. 2015. Монгол: Нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үнэлгээнд суурилсан үндэсний хэлэлцүүлэг. ОУХБ-ын нийгмийн хамгааллын платформ.

<http://www.social-protection.org/gimi/gess/ShowProject.action?id=2287>.

Пейрон Биста, С; Амгалан, Л; Санжжав, Б; Төмөртүлга,Б. 2015. Нийгмийн хамгааллын үнэлгээнд суурилсан үндэсний хэлэлцүүлэг: Монгол Улсын нийгмийн хамгааллын суурь түвшний тодорхойлолт, зардал (Улаанбаатар, ОУХБ).

ван Лангенхов, Т. 2015. НЦҮ-ний талаарх орон нутгийн үнэлгээний тайлан, цаашид боловсронгуй болгох зөвлөмж, 2015 (ОУХБ, завсрын хувилбар).

Швейцарийн хөгжлийн агентлаг.2013. Товч мэдээлэл-Засаглалыг дэмжих, төвлөрлийг сааруулах хөтөлбөр: Модуль 4.1. (Улаанбаатар).

https://www.eda.admin.ch/content/dam/countries/countries-content/mongolia/en/resource_en_229882.pdf.

–. 2013. Швейцарийн хамтын ажиллагааны стратеги, Монгол Улс, 2013-2016. (Берн).

https://www.eda.admin.ch/content/dam/countries/countries-content/mongolia/en/resource_en_219861.pdf.

–. 2015. Төслийн веб хуудас.

<https://www.eda.admin.ch/countries/mongolia/en/home/international-cooperation/projects.html/content/projects/SDC/en/2012/7F08183/phase2.html?oldPagePath=/content/countries/mongolia/en/home/internationale-zusammenarbeit/projekte.html>.

Нийгмийн хамгааллын тухай мэдээллийн энэхүү хураангуйг ОУХБ-ын Тибо ван Лангенхов, Селин Пейрон Биста нар бэлтгэж, Валери Шмит, Изабель Ортиз нар хянав.

Мэдээллийн цувралын редактор- Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Нийгмийн хамгааллын газрын захирал Изабель Ортиз.

Нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу: ortizi@ilo.org

Манай www.social-protection.org вебсайтад зочилно уу.



ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН ТОВЧОО

4, route des Morillons
1211 Genève 22
Switzerland



www.facebook.com/SPplatform



www.linkedin.com/groups?gid=6707223



www.twitter.com/soc_protection



www.youtube.com/user/SPFinAsia

